

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2025/004/НА-СТА-ОНӨҮГ

::

Цахим хуудас: www.audit.mn Баянхонгор хот 2025.03.15	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: М.Алтантуяа Утас: 99061829 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Аудитор: А.Адилзаяа Утас: 80870886 Цахим хаяг: adilzayaa@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН	6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	11
4. АУДИТЫН ТАЙЛАН	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	15
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	18

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

310 дугаар байр, Луасанданзавьжэнцэргийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дугаар баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2/99

танай _____-ны № _____-т

Хязгаарлалтай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Аудитаар илэрсэн нийт зөрчил нь урьдчилан тогтоосон гүйцэтгэлийн материаллаг байдлын түвшин 23,775.6 мянган төгрөгөөс хэтэрсэн.

Үүнд:

- Тайлант онд 72,672.4 мянган төгрөгийн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авч 72,170.2 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах комиссын гаргасан шийдвэр, акт хангалтгүй хуралдааны тэмдэглэл байхгүй байна.
- Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах нийт 33,680.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг гүйцэтгүүлэхдээ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу харьцуулалтын аргаар бус шууд гэрээ байгуулсан.
- Тайлант оны НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын дүн санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын дүнгээс 89,327.5 мянган төгрөгийн зөрүүтэй.

5020442

Дээрх зөрчлүүд нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар", Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.1, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт болон Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Хот суурины ус хангамж ариутгах татуургын ашиглалт, үйлчилгээг зохицуулах хорооны 2024 оны 05 дугаар сарын 31-ны өдрийн 53 тоот тогтоолоор Чандмань Баянхонгор ХК-ийн цэвэр бохир усны үйлчилгээний үнэ тарифыг нэмэгдүүлж 2024 оны 07 дугаар сарын 01-ны өдрөөс үйлчилгээндээ мөрдөж эхэлсэнтэй холбоотой байгууллагын бизнес төлөвлөгөөний нийт орлогыг 3,680,098.4 мянга, нийт зардлыг 3,657,797.4 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 9 зорилт, 47 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгаж, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 82.7 хувиар үнэлсэн байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх

үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Б.МӨНХБАТ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

ЭЗА	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Үлдэгдэл	
		2023 он	2024 он
А	Б	1	2
1	ХӨРӨНГӨ		
1.1	Эргэлтийн хөрөнгө		
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	459,757,622.55	239,474,505.97
1.1.2	Дансны авлага	176,735,804.08	150,476,672.58
1.1.7	Бараа материал	182,486,909.54	232,600,073.54
1.1.8	Урьдчилж гарсан зардал	181,038,891.08	200,555,711.56
1.1.20	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,000,019,227.25	823,106,963.65
1.2	Эргэлтийн бус хөрөнгө		
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,920,156,725.61	3,902,556,121.28
1.2.7	Биет бус хөрөнгө	615,861,982.95	610,203,246.88
1.2.20	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	4,536,018,708.56	4,512,759,368.16
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,536,037,935.81	5,335,866,331.81
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	3,536,571.24	-
2.1.1.3	Татвар-ын өглөг	2,564,791.31	9,725,787.71
2.1.1.4	НДШ-ийн өглөг	1,879,008.04	-
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	308,550	-
2.1.1.20	Богино хугацаат өр төлбөрийн дүн	8,288,920.59	9,725,787.71
2.1.2	Урт хугацаат өр төлбөр		
2.1.2.4	Бусад урт хугацаат өглөг	84,361,356.67	66,780,510.98
2.1.2.20	Урт хугацаат өр төлбөрийн дүн	88,178,295.16	66,780,510.98
2.1.2.20	Өр төлбөрийн нийт дүн	96,467,215.75	76,506,298.69
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ		
2.2.1	Өмч : а) төрийн	313,835,027.38	313,835,027.38
2.2.2	б) хувийн	78,458,800.00	78,458,800.00
2.2.4	Хувьцаат капиталын дүн	392,293,827.38	392,293,827.38
2.2.6	Дахин үнэлгээний нөөц	609,365,573.82	609,365,573.82
2.2.7	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	4,173,021,544.69	4,299,021,544.69
2.2.8	Хуримтлагдсан ашиг (алдагдал)	264,889,774.17	(41,320,912.77)
2.2.20	Эзэмшигчдийн өмчийн дүн	5,439,570,720.06	5,259,360,033.12
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	5,536,037,935.81	5,335,866,331.81

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

/төгрөгөөр/

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

ЭЗА	Үзүүлэлт	2023 он	2024 он
1	Борлуулалтын орлого /цэвэр/	2,584,345,574.80	3,310,059,045.62
2	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	2,724,603,657.54	3,559,791,608.41
3	Нийт ашиг (алдагдал)	(140,258,082.74)	(249,732,562.79)
5	Хүүний орлого	2,958,815.39	2,060,343.59
8	Бусад орлого	107,945,551.68	251,160,840.09
10	Ерөнхий ба удирдлагын зардал	109,851,518.06	155,565,502.13
12	Бусад зардал	33,020,110.84	154,133,805.70
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз /гарз/		
17	Бусад ашиг /алдагдал/	(73,546,947.83)	
18	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(245,772,292.40)	(306,210,686.94)
19	Орлогын татварын зардал		
20	Татварын дараах ашиг (алдагдал)	(245,772,292.40)	(306,210,686.94)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

ЭЗА	ҮЗҮҮЛЭЛТ	2023 он	2024 он
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн	2,849,627,678.30	3,951,840,045.51
1.1.1	Бараа борлуулсан үйлчилгээний орлого	2,749,204,632.51	3,618,047,020.72
1.1.4	Буцаан авсан албан татвар	(3,322,505.89)	-
1.1.6	Бусад мөнгөн орлого	103,745,551.68	333,793,024.79
1.2	Мөнгөн зарлагын дүн	2,882,371,605.05	4,124,543,230.80
	Ажилчдад төлсөн	783,585,246.39	1,229,879,356.04
	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	292,359,533.85	413,283,898.65
	Бараа материал худалдан авахад төлсөн мөнгө	637,972,629.73	974,618,693.30
	Ашиглалтын зардалд төлсөн	260,743,446.35	314,570,828.71
	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	208,833,650.00	417,021,020.00
	Хүүний төлбөрт төлсөн	10,420,285.32	
	Татварын байгууллагад төлсөн	322,621,592.64	378,494,634.44
	Бусад мөнгөн зарлага	365,835,220.77	396,674,799.66
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(32,743,926.75)	(172,703,185.29)

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн	2,958,815.39	2,060,343.59
	Хүлээн авсан хүүний орлого	2,958,815.39	2,060,343.59
2.2	Мөнгөн зарлагын дүн	-	
	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		234,402,482.41
	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,958,815.39	2,060,343.59
3.2	Мөнгөн зарлагын дүн	35,852,682.00	49,640,274.88
	Зээл авсан, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	34,132,682.00	41,640,274.88
	Бусад зарлага	1,720,000.00	8,000,000.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(35,852,682.00)	(49,640,274.88)
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(65,637,793.36)	(220,283,116.58)
5.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		459,757,622.55
5.2	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	459,757,622.55	239,474,505.97

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

	ҮЗҮҮЛЭЛТ	Хувьцаат капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эзэмшигчдийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг алдагдал	Нийт дүн
1	2023 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	6,809,779,984.66	518,152,656.37	8,329,592,042.23
3	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	6,809,779,984.66	518,152,656.37	8,329,592,042.23
8	Тайлант үеийн цэвэр ашиг				(253,262,882.20)	(253,262,882.20)
10	Бусад дэлгэрэнгүй орлого			(2,636,758,439.97)		(2,636,758,439.97)
11	2023 оны 12-р сарын 31 -ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,173,021,544.69	264,889,774.17	5,439,570,720.06
12	Бүртгэлийн бодлогын өөрчлөлт					-
13	Залруулсан үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,173,021,544.69	264,889,774.17	5,439,570,720.06
19	Тайлант үеийн цэвэр ашиг				(306,210,686.94)	(306,210,686.94)

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

21	Бусад дэлгэрэнгүй орлого			126,000,000.00		126,000,000.0
21	2024 оны 12-р сарын 30-ний үлдэгдэл	392,293,827.38	609,365,573.82	4,299,021,544.69	(41,320,912.77)	5,259,360,033.12

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний тайлан

/мянган төгрөгөөр/

Орлогын төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Цэвэр усан хангамж	897,547.00	1,184,719.5	1,102,540.47	(82,179.03)	93.1%
Ариутгах татуурга	567,934.00	791,685.9	741,028.62	(50,657.23)	93.6%
Дулаан хангамж	793,482.00	1,183,984.1	1,104,980.43	(79,003.67)	93.3%
Суурь хураамж	159,177.00	177,616.3	177,630.6	14.3	100.0%
УТБ	135,888.00	155,595.3	154,614.9	(980.4)	99.4%
Бусад	141,221.94	186,497.5	282,485.2	95,987.70	151.5%
Нийт борлуулалт	2,695,249.94	3,680,098.50	3,563,280.23	(116,818.27)	96.8%
Цалин түүнтэй адилтгах зардал	1,215,209.16	1,786,019.18	1,719,322.71	66,696.47	96.3%
Цалин түүнтэй адилтгах зардал	893,537.51	1,350,253.16	1,336,866.43	13,386.73	99.0%
НДШ -АО	155,418.44	217,053.72	198,739.87	18,313.85	91.6%
Улиралын үр дүн 45%, урамшуулал	125,953.93	170,897.11	143,571.31	27,325.79	84.0%
ТУЗ цалин	36,207.80	41,760.00	35,760.00	6,000.00	85.6%
ТУЗ НДШ	4,091.48	6,055.20	4,385.10	1,670.10	72.4%
Нийгмийн хамгаалал ажиллагсадтай холбоотой зардал	112,505.121	178,150.76	124,848.64	53,302.12	70.1%
Тэтгэмж	18,923.01	45,695.26	38,507.89	7,187.37	84.3%
Шагнал урамшууллын зардал	8,734.00	7,000.00	7,194.23	(194.23)	102.8%
Баяр ёслол Ажилчдын нийгмийн арга хэмжээнд	33,798.07	48,835.00	14,198.35	34,636.65	29.1%
Сургалт	4,151.00	17,662.20	9,271.65	8,390.55	52.5%
Албан томилолтын зардал	13,171.30	15,002.00	13,374.40	1,627.60	89.2%
Ахмадын зардал	14,173.81	14,576.00	14,405.26	170.74	98.8%
Ажилчдын хоолны зардал	19,553.94	29,380.30	27,896.86	1,483.44	95.0%
Татвар, төлбөр, хураамж, даатгал	87,429.88	99,969.47	96,893.44	3,076.02	96.9%
Татварын зардал	41,957.16	42,843.30	37,551.68	5,291.62	87.6%
Даатгал	2,657.53	3,649.85	3,448.37	201.47	94.5%
Төрийн аудит, мэдээлэл Аюулгүй байдлын аудит	4,500.00	10,000.00	10,400.00	(400.00)	104.0%

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Орлогын төрөл	2023 оны гүйцэтгэл	2024 оны		Зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
Зохицуулах зөвлөл, тусгай зөвшөөрөл	14,023.60	16,007.47	16,178.87	(171.40)	101.1%
Түрээсийн зардал	7,507.59	7,359.30	7,309.86	49.44	99.3%
банкны шимтгэл хураамж	2,107.31	2,205.00	2,027.63	177.37	92.0%
Гадны үйлчигээний зардал	5,384.50	5,922.95	7,076.80	(1,153.85)	119.5%
Ритус , ABIS ECM биллинг программын зардал	6,379.50	11,981.60	12,843.66	(862.06)	107.2%
Алданги торгуулийн зардал	2,912.70	-	56.58	(56.58)	
Ашиглалтын зардал	761,870.17	707,517.40	699,561.12	7,956.28	98.9%
Эрчим хүч	255,109.70	277,642.51	274,540.62	3,101.89	98.9%
Үндсэн хөрөнгийн элэгдэл	493,352.90	415,166.49	415,161.82	4.67	100.0%
Харилцаа холбооны зардал	13,407.58	14,708.40	9,858.67	4,849.73	67.0%
/материал/ сэлбэг хэрэгсэл	510,256.76	679,918.20	875,380.85	(195,462.65)	128.7%
Түлш, халаалтын зардал	288,425.82	457,969.76	601,418.51	(143,448.75)	131.3%
Шатах тослох материал	84,690.89	87,511.47	112,557.82	(25,046.35)	128.6%
сэлбэг хэрэгсэл /материал/	51,555.28	46,542.40	85,948.29	(39,405.89)	184.7%
Бичиг хэргийн зардал	5,429.68	16,217.29	16,465.42	(248.14)	101.5%
Ариутгал , /шинжилгээ	1,086.68	6,350.00	6,795.05	(445.05)	107.0%
Хөдөлмөр хамгаалал, хангамжийн зардал	81,827.78	52,599.90	46,359.87	6,240.03	88.1%
Цэвэрлэгээний зардал	4,544.42	4,928.80	5,835.90	(907.10)	118.4%
Гамшгаас хамгаалах зардал		7,798.59	-	7,798.59	0.0%
Засвар үйлчилгээний зардал	253,751.17	232,222.4	353,484.23	(121,261.83)	152.2%
Засвар үйлчилгээний зардал	120,544.00	126,222.4	146,652.74	(20,430.34)	116.2%
Гэрээт ажлын зардал	45,526.67	71,000.0	54,917.03	16,082.97	77.3%
Үйл ажиллагааны бус зардал	73,546.90	35,000.0	131,671.96	(96,671.96)	376.2%
Хөрөнгө акталсны гарз	14,133.60	-	-	-	
Хүүгийн зардал			20,242.50	(20,242.50)	
Нийт Борлуулалт	2,695,249.94	3,680,098.8	3,563,280.23	116,818.58	96.8%
Нийт зардал	2,941,022.26	3,683,797.41	3,869,491.00	(185,693.59)	105.0%
Ашиг алдагдал	(245,772.32)	(3,698.6)	(306,210.77)		
Орлогын татварын зардал	-	(369.9)			
Цэвэр ашиг		(3,328.7)			

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Компани/ТӨҮГ, түүний үйл ажиллагаа

Чандмань Баянхонгор ХК нь “Чадварлаг хүний нөөц, байгальд ээлтэй дэвшилтэт технологиор ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг хэрэглэгчдэд хүргэж, хөгжилд тэмүүлсэн манлайлагч байгууллага болно” гэсэн эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааныхаа хүрээг тодорхойлжээ.

Тус байгууллага нь захиргаа аж ахуй, цэвэр ус, ариутгах татуургын алба, дулааны алба гэсэн 3 албанд нийт 92 ажилтантайгаар Баянхонгор сумын хэмжээнд цэвэр ус олборлон түгээх, бохир усыг татан зайлуулж, аймгийн төвийн зарим хэсгийн хэрэглэгчдийг дулаанаар ханган ажиллаж байна.

3.2 Компани/ТӨҮГ-ын гадаад, дотоод орчин

Чандмань Баянхонгор ХК нь анх 1965 онд Үйлчлэх товчоо нэртэйгээр аймгийн төвийн хүн ам, орон сууцны халаалт, цахилгаан эрчим хүч, усан хангамж, хог тээвэр, халуун ус, хот тохижилт зэрэг үйл ажиллагаагаа эхэлсэн байна.

Аймгийн ИТХ-ын 2012 оны 10 дугаар сарын 11-ны өдрийн ээлжит бус XVIII хуралдаанаар “Чандмань Баянхонгор” ХХК-ийг хаалттай хувьцаат компанийн хэлбэрээр өөрчлөн зохион байгуулахаар шийдвэрлэж, 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдөр улсын бүртгэлд бүртгүүлсэн байна. Хаалттай хувьцаат компанийг хуулийн дагуу зохион байгуулаагүйгээс тус компанийн үйл ажиллагаа нь хязгаарлагдмал хариуцлагатай компанийн зарчмаар ажиллаж ирсэн байна.

Дотоод аудитын чиг үүргийг аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба хэрэгжүүлдэг бөгөөд санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийгдээгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Чандмань Баянхонгор ХК нь 2024 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Хот суурины ус хангамж, ариутгах татуургын үйлчилгээг зохицуулах хорооноос гаргасан “Орон сууц, нийтийн аж ахуйн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн жишиг баримт бичиг”-ийг үйл ажиллагаандаа ашиглаж, санхүүгийн тайлан бэлтгэхдээ мөрдөж ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1. Аж ахуйн нэгж, байгууллага дараах

бүртгэлийн стандартыг дагаж мөрдөнө: 4.1.3-д "Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 5,335,866.3 мянган төгрөг болж өмнөх оноос 200,171.6 мянган төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

ЭЗА	БАЛАНСЫН ЗҮЙЛ	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Зөрүү
1.1	Эргэлтийн хөрөнгө	1,000,019.2	823,106.9	(176,912.2)
1.1.1	Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	459,757.6	239,474.5	(220,283.1)
1.1.2	Дансны авлага	176,735.8	150,476.6	(26,259.1)
1.1.7	Бараа материал	182,486.9	232,600.0	50,113.1
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	4,536,018.7	4,512,759.3	(23,259.3)
1.2.1	Үндсэн хөрөнгө	3,920,156.7	3,902,556.1	(17,600.6)
	Хуримтлагдсан элэгдэл	1,779,366.6	2,188,869.7	409,503.0
1.2.7	Биет бус хөрөнгө	615,861.9	610,203.2	(5,658.7)
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	5,536,037.9	5,335,866.3	(200,171.6)
2.1	ӨР ТӨЛБӨР	96,467.2	76,506.2	(19,960.9)
2.2	ЭЗЭМШИГЧДИЙН ӨМЧ	5,439,570.7	5,259,360.0	(180,210.6)
2.3.20	НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨМЧИЙН ДҮН	5,536,037.9	5,335,866.3	(200,171.6)

Авлагын дансны эцсийн үлдэгдэл 150,476.6 мянган төгрөг болж эхний үлдэгдлээс 26,259.1 мянган төгрөгөөр буурсан нь харилцагч байгууллагуудаас авах дансны авлага буурсантай холбоотой байна.

Тайлант онд бараа материалын данс 232,600.0 мянган төгрөг болж эхний үлдэгдлээс 50,113.1 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалаас 22,210.2 мянган төгрөг, сантехникийн материал 39,299.4 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэл голлох нөлөөг үзүүлжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,902,556.1 мянган төгрөг болж 17,600.6 мянган төгрөгөөр буурсан нь төсвийн хөрөнгөөр 235,902.4 мянга, аймгийн ИТХ-ын даргын 2024 оны 04-р сарын 03-ны өдрийн 25 дугаар захирамжаар 156,000.0 мянган төгрөгийн Hubei Runli маркын 2 ширхэг автомашин хүлээн авсан бол тайлант оны үндсэн хөрөнгийн хуримтлагдсан элэгдэл 409,503.0 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

3.5 Зорилтот түвшний төлөвлөгөө, гүйцэтгэл

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2024 оны бизнес төлөвлөгөөнд нийт зардлыг 3,433,616.6 мянган төгрөгөөр, нийт борлуулалтын орлогыг 3,275,321.4 мянган төгрөгөөр тооцон баталсан бол Чандмань ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны 07-р сарын 25-ны өдрийн 7 дугаар тогтоолоор тус байгууллагын цэвэр бохир усны үнэ тариф нэмэгдсэнтэй холбогдуулан нийт зардлыг 3,657,797.4 мянга, нийт орлогыг 3,680,080.8 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоосон байна.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34 дүгээр зүйлд заасны дагуу байгууллагын худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгасан 160,001.0 мянган төгрөгийн түлш шатахууны тендер, Баянхонгор аймгийн Засаг даргын 2024 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн А/243 дугаартай “Ус хангамж, эрүүл ахуйн шаардлага хангасан лабораторийн тоног төхөөрөмжийн ажлыг эрх шилжүүлэн гүйцэтгэх тухай” тогтоолоор 107,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий тоног төхөөрөмжийн тендерийг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар зохион байгуулсан байна.

- 160,001.0 мянган төгрөгийн түлш шатах, тослох материал худалдан авах тендерийг 2024 оны 07-р сарын 05-ны өдөр худалдан авах ажиллагааны цахим хуудас /tender.gov.mn/-т нийтэлж НИК ХХК 155,870.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлснээр 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдрөөс эхлэн 1 жилийн хугацаанд шатахуун нийлүүлэхээр к-42 дугаартай гэрээ байгуулж гэрээний дагуу шатахуун худалдан авч байна.
- Эрх шилжүүлсэн 107,000.0 мянган төгрөгийн өртөг бүхий “Ус хангамж, эрүүл ахуйн шаардлага хангасан лабораторийн тоног төхөөрөмж” худалдан авах тендерийг 2024 оны 08 дугаар сарын 28-ны өдөр худалдан авах ажиллагааны цахим хуудас /tender.gov.mn/-т нийтэлж Синапс ХХК 103,224.0 мянган төгрөгийн үнийн санал ирүүлснээр 2024 оны 10 дугаар сарын 16-ны өдрийн ЧБХХК/20246001 дугаартай гэрээгээр тоног төхөөрөмж нийлүүлэх гэрээ байгуулсан боловч цаг үеийн нөхцөл байдлаас хамаарч нийлүүлэгч компаниас гэрээг сунгах хүсэлт гаргасны дагуу 2025 оны 01 дүгээр сарын 19-ны өдрөөр гэрээ дүгнэх акт үйлдэж тоног төхөөрөмжийг хүлээн авсан байна.
- Тайлант оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй “Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах” нийт 33,680.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг "Инж байгууламж ХХК"-тай шууд гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг зөрчсөн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор А.Адилзаяа гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер М.Алтантуяа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Чандмань ХК-ийн 2024 оны санхүүгийн тайланд аудит хийлгэх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн 74 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2024 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2024 оны бизнес төлөвлөгөөний нийт зардлын дүн болох 3,657,797.4 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 36,577.9 мянга, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 23,775.6 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

4.3.1 Тайланд онд тус байгууллага нь Ахмад настны тухай хуулийн 12 дугаар зүйл 12.1-т заасны дагуу байгууллагын төсвөөс ахмадуудад гарын бэлэг гардуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.7 “Төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл худалдан авахыг хориглоно” гэснийг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын сангаас холбогдох зардлыг зарцуулж байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст мэдээлбэл зохих хуулийн 6.4.5-т заасан цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 1,010,198.5 мянган төгрөгийн 82 гүйлгээ, зарлагын 1,498,485.0 мянган төгрөгийн 96 гүйлгээг бүрэн мэдээлсэн байна.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тайлант хугацаанд завсар үеийн аудит хийгдээгүй болно.

4.5.1 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Бүнчинсүрэн гүйцэтгэж аудитаар нийт 387,824.4 мянган төгрөгийн 6 албан шаардлага өгснийг бүрэн биелүүлсэн талаар тус байгууллагаас FAS программд хэрэгжилтийг мэдээлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	6	387,824.4	6	387,824.4	100%
Нийт дүн	6	387,824.4	6	387,824.4	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 35,551.7 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснээс аудитын явцад 35,551.7 мянган төгрөгийн алдааг залруулсан болно. Үүнд:

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

5.1.1 Инж байгууламж ХХК-тай АЗТ-03/24 дугаартай "Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах гэрээ"-ээр нийт 33,680.4 мянган төгрөгийн үнэ бүхий зураг төсвийн ажлын гэрээ байгуулж гэрээний 1.5-д заасны дагуу урьдчилгаа 50 хувь болох 16,840.2 мянган төгрөгийг олгосон боловч тус зураг төсөв нь Барилга хөгжлийн төвийн магадлалаар орж баталгаажиж хүлээн аваагүй тул ажлын урьдчилгааг авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Инж байгууламж ХХК-тай байгуулсан гэрээний 2 зүйл 2.1, 2.2 дахь заалтууд, УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт батламж мэдэгдэлтэй тус нийцэхгүй байна.

5.1.2 Дамжуулан зээлдүүлэх МОН-1847 зээлийн тайлант оны хүүгийн төлбөрийн өглөгийг үндсэн зээлээс салгаж санхүүгийн тайланд тусгаагүй байсныг аудитын явцад залруулав.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 "Үнэн зөв байх", УСНББОУС-19 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, НББОУС-37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 Иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх стандартуудтай нийцэхгүй байна.

Аудитаар нийт 513,180.9 мянган төгрөгийн 6 зөрчил² илэрснээс 206,970.3 мянган төгрөгийн 4 албан шаардлага, 306,210.6 мянган төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн.

5.2 Зөвлөмж

5.2.1 Илрүүлэлт: Тус байгууллага нь 2024 оны 07 сарын 01-ээс нэмэгдсэн цэвэр бохир усны үнэ тариф бүрэн мөрдөөгүй, урсгал засварыг цаг хугацаанд хийгээгүй, зарим хэрэглэгчдэд ТУЗ-ын шийдвэргүйгээр хөнгөлөлт үзүүлсэн зэргээс шалтгаан 306,210.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын менежментийн үйл ажиллагааг сайжруулах заалтыг гүйцэтгэх захирлын гэрээнд оруулж компанийн тайлант оны үйлдвэрлэл, борлуулалтын төлөвлөгөө, гүйцэтгэлд улирал бүр хяналт тавьж шуурхай арга хэмжээ авч ажиллах замаар алдагдлыг бууруулах зөвлөмжийг Чандмань Баянхонгор ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд өгч байна.

5.2.2 Илрүүлэлт: Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн "Орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр ашиглалт үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" жишиг бодлогод үйлчилгээний үнэ тарифт хөнгөлөлт үзүүлэх заалт тусгаагүй байхад байгууллагын захирлын тушаалаар хэрэглэгчдэд халаалтын төлбөрөөс хөнгөлөлт үзүүлсэн байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2 "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана”, 20 дугаар зүйл 20.2.2 “Ерөнхий нягтлан бодогч аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах үүрэг хүлээнэ” заалтуудтай нийцэхгүй байна

Шийдвэрлэсэн нь: НБББББ-т заасны дагуу нягтлан бодох бүртгэлийг аккрузал сууриар үнэн зөв хөтлөх зөвлөмж хүргүүлэв.

5.3 Албан шаардлага

5.3.1 Тайлант онд 72,672.4 мянган төгрөгийн автомашины сэлбэг хэрэгсэл худалдан авч 72,170.2 мянган төгрөгийн зарлага гаргасан ба тухайн авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах комиссын гаргасан шийдвэр, акт, хангалтгүй хуралдааны тэмдэглэл байхгүй байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Өмч хамгаалах зөвлөлийн үйл ажиллагааны нийтлэг журам"-ын 3.13-т "Өмч хамгаалах зөвлөл нь хуулийн этгээдийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн ашиглалт, сэлбэг эд ангийг солих, барилга байгууламжийн их засвар хийх тохиолдолд батлагдсан норм стандартыг мөрдүүлэх, барилгын болон техникийн хувийн хэрэгт нь баяжилт хийлгэх зэргээр хяналт тавьж ажиллана" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын өмч хамгаалах зөвлөл нь тээврийн хэрэгслийн сэлбэг, эд ангийг солихдоо батлагдсан норм стандартын дагуу тухай бүр дүгнэлт гаргаж зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3.2 Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах нийт 33,680.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасны дагуу тендер зарлаагүй "Инж байгууламж ХХК"-тай шууд гэрээ байгуулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 10 дугаар зүйл 10.2 “Энэ хуулийн 31.2-т зааснаас бусад тохиолдолд нийт төсөвт өртөг нь шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээг захиалагч шууд худалдан авч болно”, МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар", УСНББОУС 29 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт, НББОУС 39 Санхүүгийн хэрэглүүр: хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт болон Нийцсэн бөгөөд зохистой байх гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна

Шийдвэрлэсэн нь: Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2.3 Тус байгууллага нь байгууллагын ахмадын санд жил бүр мөнгө төвлөрүүлдэг атлаа байгууллагын зардлаас 11,290,000 (Арван нэгэн сая хоёр зуун ерэн мянга) төгрөгийг нэмэлт зардал гарган цагаан сар болон ахмадын баяраар гарын бэлэг, ахмадын зөвлөлийн даргад мөнгөн урамшуулал олгосон байна.

Энэ нь Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, 14 дүгээр зүйл 14.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ахмадын санд төвлөрүүлсэн хуримтлалаас Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйл 14.7-д заасны дагуу зарцуулж байх, үйл ажиллагааны зардлаас нэмэлт зардал гаргадгийг таслан зогсоож, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

5.3.4 Тайлант оны НӨАТ-ын тайлангаарх борлуулалтын дүн санхүүгийн үр дүнгийн тайлангийн борлуулалтын дүнгээс 89,327.5 мянган төгрөгийн зөрүүтэй байна.

Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.1 “Албан татвар суутган төлөгч буцаан авах хүсэлтээ албан татварын тооцоо хийж, тайлан тушаах үедээ харьяалах татварын албанд бичгээр, эсхүл цахим хэлбэрээр ирүүлнэ”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл 5.1.4 “Үнэн зөв байх” заалтад нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид нэмэгдсэн өртгийн албан татварыг зөв тайлагнаж байх, зөрчлийг арилгах албан шаардлага хүргүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Инж байгууламж ХХК-тай байгуулсан "Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах гэрээ"-ээр нийт 33,680.4 мянган төгрөгийн үнэ бүхий ажлын гэрээ байгуулж гэрээний 1.5-д заасны дагуу урьдчилгаа 50 хувь 16,840.2 мянган төгрөгийг шилжүүлэн зураг төслийг 100 хувь гүйцэтгэн магадлал хийлгэхээр Барилгын хөгжлийн төвд шилжүүлсэн боловч газар олгогдоогүй шалтгаанаар магадлал хийгээгүй байна. Үүнээс шалтгаалж гүйцэтгэгч компанид олгох үлдэгдэл ажлын хөлс 16,840.2 мянган төгрөгийг олгоогүй, тус компани руу шилжүүлсэн урьдчилгааг авлагаар тусгаагүй байна. Иймд байгууллагад шилжүүлсэн урьдчилгаа төлбөрийн НӨАТ-ын дүнг авлагаар тусгах боломжгүй тул хассан дүнгээр авлагаар тусгав.	1	15,309.2	1	15,309.2			1	15,309.2				

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Дамжуулан зээлдүүлэх МОН-1847 зээлийн тайлант оны хүүгийн төлбөрийн өглөгийг үндсэн зээлээс салгаж санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	20,242.5			1	20,242.5	1	20,242.5				
Дүн	2	35,551.7	1	15,309.2	1	20,242.5	2	35,551.7				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Тайлант онд авто тээврийн хэрэгслийн ашиглалт, сэлбэг эд ангийг солихдоо байгууллагын өмч хамгаалах комиссын гаргасан шийдвэр, акт, хангалтгүй хуралдааны тэмдэглэл байхгүй байна. Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2018 оны 04 сарын 03-ны өдрийн 86 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан заалтыг зөрчсөн байна.	1	72,672.4			1	72,672.4							
Ус хангамжийн өргөх насос станцын ажлын зураг төсөл боловсруулах нийт 33,680.4 мянган төгрөгийн төсөвт өртөг бүхий ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулаагүй буюу "Инж байгууламж ХХК"-тай шууд гэрээ байгуулсан байна. Энэ нь МУ-ын Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолд заасан "Шууд худалдан авах барааны төсөвт өртгийн дээд хязгаар"-ыг зөрчсөн байна.	1	33,680.4			1	33,680.4							
Тус байгууллага нь байгууллагын ахмадын санд жил бүр мөнгө төвлөрүүлдэг атлаа байгууллагын зардлаас 11,290,000 төгрөгийг нэмэлт зардал гарган цагаан сар болон ахмадын баяраар гарын бэлэг, ахмадын зөвлөлийн даргад мөнгөн урамшуулал олгосон байгаа нь Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйл 4.1.2, 14 дүгээр зүйл 14.7, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.7 дахь заалтуудыг зөрчсөн байна.	1	11,290.0			1	11,290.0							
Тайлант оны НӨАТ-ын тайланг борлуулалтын тайлантай тулган	1	89,327.5			1	89,327.5							

Чандмань Баянхонгор ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

шалгахад 89,327,535.7 төгрөгийн зөрүүтэй байна. Энэ нь Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйл 15.1.1 дугаар заалтад нийцэхгүй байна.												
Тус байгууллага нь 2024 оны 07 сарын 01-ээс нэмэгдсэн цэвэр бохир усны үнэ тариф бүрэн мөрдөөгүй, урсгал засварыг цаг хугацаанд хийгээгүй, зарим хэрэглэгчдэд ТУЗ-ын шийдвэргүйгээр хөнгөлөлт үзүүлсэн зэргээс шалтгаан 306,210.6 мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.	1	306,210.6					1	306,210.6				
Тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн “Орон сууц нийтийн аж ахуйн чиглэлээр ашиглалт үйлчилгээ явуулдаг аж ахуйн нэгж байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг” жишиг бодлогод үйлчилгээний үнэ тарифт хөнгөлөлт үзүүлэх заалт тусгаагүй байхад байгууллагын захирлын тушаалаар хэрэглэгчдэд халаалтын төлбөрөөс хөнгөлөлт үзүүлсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 18 дугаар зүйл 18.2, 20 дугаар зүйл 20.2.2 заалтуудтай нийцэхгүй байна	1	-					1	-				
Дүн	6	513,180.9			4	206,970.3	2	306,210.6				

-----oOo-----